



**ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/55

Улаанбаатар хот

Ковид-ын шинэ хувилбарт Омикрон
вируст халдварт өвчнөөс урьдчилан
сэргийлэх зарим арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.10 дахь заалт, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.4 дахь заалт, Нийслэлийн онцгой комиссын 2021 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 11 дугаартай хурлын тэмдэглэл, “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.8.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өмнөд Африкаас гаралтай Ковидын шинэ хувилбарт Омикрон вируст халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаа сэргээх нэмэлт тунд байгууллагын ажилтнуудын хамрагдалтыг нэмэгдүүлэх хүрээнд, ажилтнуудын дархлааг дэмжих бүтээгдэхүүн авах зардалд 3 250 000 (Гурван сая хоёр зуун тавин мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Дархлаа дэмжих бүтээгдэхүүн хүлээн авах ажилтнуудын нэрсийг нэгдүгээр хавсралтаар, зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Дархлаа дэмжих бүтээгдэхүүн худалдан авах зардлыг байгууллагын 2021 оны зардлын үйл ажиллагааны бус зардлаас гаргахыг нягтлан бодогч (О.Бямбасүрэн)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлага, санхүүгийн дарга (Л.Эрдэнэбат)-д даалгасугай.

ДАРГА



Ч.РЭГЗМАА

3150600525